

АГУУЛГА

НЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ	5
ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	19
ДӨРӨВ. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	20
ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	21
ЗУРГАА. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	21
ДОЛОО. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	21
НАЙМ. ОСОЛ, ЭРСДЭЛ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	23
ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	24
АРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	29
ДҮГНЭЛТ.....	29

НЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1.Төслийн ерөнхий мэдээлэл

Хүснэгт 1. Төслийн ерөнхий мэдээлэл

№	Үзүүлэлтүүд	Утга
1	Төсөл хэрэгжүүлэгч байгууллага	“ХОНГ ДА ИНТЕРНЭШНЛ” ХХК
2	Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 1-р хороо, “Монноос” ХК-ийн байр, 102 тоот Утас: (976)-324942, (976)-88108447
3	Төслийн нэр	Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших “Ногоон дов” нэртэй тоосгоны шаврын ордыг ил уурхайн аргаар ашиглах
4	Хүчинтэй хууль эрх зүйн баримт бичгийн жагсаалт	а. ААН-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ: Улсын бүртгэлийн дугаар: 9019009064 Улсын регистрийн дугаар: 2861976 Улсад бүртгүүлсэн: 2006.03.31 б. Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл: Дугаар: MV-012112 Олгосон огноо: 2007.01.29
5	Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн талбайн солбилцол	Талбай: 20.6 га Газар зүйн солбилцол: (L-48-11) 1. 107° 18' 23.38" 47° 45' 48.77" 2. 107° 17' 43.37" 47° 45' 48.77" 3. 107° 17' 43.37" 47° 45' 56.78" 4. 107° 18' 23.38" 47° 45' 56.78"
6	Ордын тоосгоны шаврын анх батлагдсан геологийн нөөц	418.36 мян.м ³
7	Өмнөх жилүүдэд олборлосон нөөц	60.52 мян.м ³
8	Ордын хэмжээн дэх одоогийн үлдэгдэл нөөц	357.84 мян.м ³
8	Ордын тоосгоны шаврын үйлдвэрлэлийн нөөц	349.36 мян.м ³
10	Жилийн хүчин чадал	Шавар олборлолт: 13.88 мян.м³ Тоосго үйлдвэрлэл: 4.0 сая.ширхэг
11	Ордын ашиглалтын хугацаа	25 жил
12	Анхны хөрөнгө оруулалт	542.06 сая.төг

1.1.1.2 Төсөл хэрэгжүүлэх талбайн байршил:

“Ногоон дов” тоосгоны шаврын орд нь MV-012112 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд хамаарагдах бөгөөд Улаанбаатар хотоос зүүн тийш 40 км, Налайх дүүргийн төвөөс зүүн зүгт 3.2 км зайд 1:100 000-ны масштабтай байрзүйн зургийн L-48-11 тоот хавтгайд 20.6 га талбайг эзлэн дараах солбилцолд оршино.

Хүснэгт 2. Газарзүйн солбицол

№	Уртраг	Өргөрөг
1	107° 17' 21.37"	47°44' 26.77"
2	107° 17' 03.37"	47°44' 26.77"
3	107° 17' 03.37"	47°44' 35.77"
4	107° 17' 21.37"	47°44' 35.77"



Зураг 1. Төсөл хэрэгжих газрын топо зураг

Уурхайн хүчин чадал

Уурхайн хүчин чадлыг “Хонгда интернэшнл” ХХК-ийн техникийн даалгаварын дагуу жилд дунджаар 4.0 сая ширхэг тоосго үйлдвэрлэх хүчин чадлаар тооцсон ба ийм хэмжээний тоосгыг үйлдвэрлэхэд жилд дунджаар 13.88 мян.м³ шавар олборлон боловсруулах шаардлагатай болно.

Уурхайн олборлолтын үйл ажиллагаа нь хоногт 8 цагийн 1 ээлжээр ажиллах горимыг барина. Ингэснээр уг уурхай нь жилдээ 133 хоног буюу 958 цаг ажиллах юм.

Уурхайн талбайд ашиглалт явуулах дараалал

Уурхайг ашиглах дараалал нь маш энгийн бөгөөд уурхайн олборлолтын үйл ажиллагаа болон тоосго үйлдвэрлэл нь дараах технологийн үндсэн горимын дагуу явагдана.

ХӨРС ХУУЛАЛТ ► ШАВАР ОЛБОРЛОЛТ

Тоосго үйлдвэрлэл:

ТООСГО ҮЙЛДВЭРЛЭХ ► ХАТААХ ► ШАТААХ ► БЭЛЭН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ХЭРЭГЛЭГЧДЭД НИЙЛҮҮЛЭХ

Үүний зэрэгцээ уурхайн зам цэвэрлэх, хуурайшилт ихтэй үед тоосжилттой тэмцэх мөн тоног төхөөрөмжид засвар, үзлэг үйлчилгээ хийх гэх мэт туслах ажлууд тодорхой хувиар, зохион байгуулалтын дагуу хийгдэнэ.

Уурхайн үндсэн тоног төхөөрөмж

Хүснэгт 3. Ил уурхайд ашиглах тоног төхөөрөмж

№	Ажлын төрөл	Хэрэглэгдэх тоног төхөөрөмжийн нэр	Марк	Шаардагдах тоо
1	Хөрс хуулалт, овоолго	Бульдозер	Shantui SD16	1
2		Утгуурт ачигч	ZL-50	1
2	Шавар олборлолт	Экскаватор	Hyundai R500LC-7	1
3	Шавар тээвэрлэлт	Автосамосвал	HOWO-ZZ3257	1

1.2 1.6 Үйлдвэрийн хүчин чадал, ажиллах горим

Үйлдвэрийн ажиллах горим

Уг ордын уулын ажил нь улирлын чанартай явагдах бөгөөд 4-р сарын 15-наас 5-р сарын 01-нийг хүртэл бэлтгэл ажил, 5-р сарын 01-нээс 09-р сарын 30-ныг хүртэл шавар олборлолт, хөрс хуулалт, тоосго үйлдвэрлэлийн ажил явагдах буюу жилд нийтдээ 5 сар ажиллах юм.

Уурхайн олборлолтын үйл ажиллагаа нь хоногт 8 цагийн 1 ээлжээр ажиллах горимыг барина. Ингэснээр уг уурхай нь жилдээ 133 хоног буюу 958 цаг ажиллах юм.

Үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжийн иж бүрдэл

Тоосго үйлдвэрлэх үйл ажиллагаа нь түүхий эд, материалыг бутлан үйлдвэрлэлд бэлдэх, тоосго үйлдвэрлэх, хатаах, шатааж боловсруулах, эцсийн бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд нийлүүлэх гэсэн ерөнхий шат дараалалтай явагдана.



Зураг 2. Тоосго үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн дамжлага схем

1.3 1.7 Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө

“Ногоон дов” уурхай нь 2022 онд нийт 3.55 мян.м³ хөрс хуулж, 13.88 мян.м³ шавар олборлож 4.0 сая ширхэг тоосго үйлдвэрлэхээр төлөвлөсөн.

ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- ✓ Ажилчдыг нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангасан.
- ✓ Хог хаягдлын гэрээг байгуулж, хуваарийн дагуу тогтмол тээвэрлүүлсэн.
- ✓ ОХШХ-ийн хүрээнд агаар, ус, хөрсний шинжилгээ авч лабораторид шинжлүүлсэн.
- ✓ Нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж, Инновацын төв байгуулсан
- ✓ Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглах гэрээ байгуулсан /Төлбөрийн баримтыг хавсаргав/
- ✓ Туул голын сав газрын захиргаанаас усны дүгнэлт гаргуулсан

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ

2022 оны 11 сарын 14 өдөр

Дугаар 02

Налайх дүүрэг

Гэрээний зорилго: Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад “Хөдөлмөрийн тухай”, “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Ашигт малтмалын тухай”, “Хог хаягдлын тухай”, “Зөрчлийн тухай” “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” хууль холбогдох дүрэм, журам, дүүргийн удирдлагаас гарсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулж, төр захиргааны эрх бүхий байгууллагаас дэмжлэг үзүүлэн, хяналт тавих, нөгөө талаас сайн дурын үндсэн дээр орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмрийн хүрээнд нийгмийн хариуцлагыг тодорхойлж, хамтран ажиллахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

Нэг. Ерөнхий зүйл

Нэг талаас Дүүргийн удирдлагыг төлөөлж Налайх дүүргийн Засаг даргын орлогч С.Тунгалаг (цаашид “Захиргааны байгууллага” гэх), нөгөө талаас Аж ахуйн нэгж, байгууллагыг төлөөлж Налайх дүүргийн хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 2861976-ийн регистрийн дугаартай, “Талт Да Интернэйшнл ХХК” ХХК-ийн захирал Д.Ш.Хүр (цаашид “ААН, байгууллага” гэх) нар нь хамтран дараах нөхцөлүүдийг хэлэлцэн тохиролцож, харилцан зөвшөөрснөөр энэхүү гэрээг байгуулав.

- 1.1. Талууд бие биенийхээ үйл ажиллагааг харилцан хүндэтгэж, гэрээний заалтуудыг чанд мөрдөнө.
- 1.2. Гэрээг 2% үйлдэж, хоёр тал харилцан тохиролцон гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болох бөгөөд талуудад гэрээний 1 хувийг хадгалуулна.
- 1.3. Гэрээ нь 2022 оны 11-р сарын 14-ний өдрөөс 2022 оны 11-р сарын 14-ний өдөр хүртэл 1 жилийн хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөнө.
- 1.4. Аль нэг талын санаачилгаар гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд гэрээний нэгэн адил хүчин төгөлдөр үйлчилнэ.

Хоёр. Нутгийн захиргааны байгууллагын эрх, үүрэг

- 2.1. Хууль тогтоомж, дүрэм, журам, төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагаас гаргасан тогтоол, шийдвэрийг аж ахуйн нэгж, байгууллагад сурталчлах ажлыг зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай үзүүлнэ.
- 2.2. Газар ашиглах, эзэмших, ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчныг хамгаалах, түүний баялагийг зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар хууль тогтоомжинд заасан үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж, гарсан зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ авах.
- 2.3. Захиргааны байгууллага нь гэрээний хугацаанд аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн аливаа үйл ажиллагааг орон нутгийн иргэдэд тухай бүр нь үнэн зөв мэдээлж ажиллах.
- 2.4. Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтарч сургалт, семинар, үзэсгэлэн худалдаа болон бусад арга хэмжээнд оролцуулах ажлыг зохион байгуулах.

Гурав. Аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг

- 3.1. Аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, дүрэм, журам, төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагаас гаргасан тогтоол, шийдвэрийг чанд биелүүлж, олон нийтийг хамарсан арга хэмжээ болон нийгмийн дэг журмыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхи санаачлагатай оролцох.
- 3.2. Аж ахуйн нэгж, байгууллага нь орчны 50м хүртэлх газрын ашиглалт хамгаалалт, цэвэрлэгээ, халтиргаа, гулгааг хариуцан тогтмол цэвэрлэх, мод, бут, зүлэг тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, орчны тохижилтод хувь нэмрээ оруулж, гаднах хаягаа гэрэлтдэг, товгор крилл үсгээр бичиж байршуулах, гэрэлтүүлгийг стандартын дагуу хийж гүйцэтгэх, хог хаягдлын гэрээ байгуулан ажиллах.
- 3.3. Нийслэлийн агаарын бохирдлыг багасгах зорилтын хүрээнд өвлийн улиралд сэргээгдэх эрчим хүчний бие даасан үүсгүүр, стандартын шаардлага хангасан хийн болон цахилгаан халаагуур, бүрэн шаталттай шахмал түлш ашиглах.
- 3.4. Зориулалтын (2-3 хоногийн багтаамжтай) хогийн савтай байж, бохир усны цооног, бие засах газрыг стандартын шаардлага хангасан хөрс бохирдуулахгүй байдлаар шийдэх.
- 3.5. Орон нутгийн нийгмийн халамж дэмжлэг шаардлагатай өрх, иргэдэд чиглэсэн тодорхой үйл ажиллагааг санаачлан хэрэгжүүлэх.
- 3.6. Дүүрэгт ажлын байрыг нэмэгдүүлж, ажиллах хүчний 80 хүртэлх хувьд дүүргийн харьяалалтай иргэдийг хамруулж, ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулан, чадваржуулах ажлыг зохион байгуулж, ажиллагсдын хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл

болон, тухайн дүүргийн иргэдийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавьж, ажлын байран дахь аюул эрсдлийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилтантай мэдээлэл солилцож, хамтран ажиллах

3.8. Ажилчдыг нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалд хуулийн дагуу цаг хугацаанд нь хамруулах

3.9. Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана. /Хөдөлмөрийн сайдын 2016 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн №36 дугаар тушаалаар батлагдсан/

Дөрөв. Гэрээ дуусгавар болох
Дараах тохиолдолд гэрээ дуусгавар болно. Үүнд:

4.1. Гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах талаар аль нэг тал нөгөө талдаа бичгээр мэдэгдсэн боловч нөгөө тал нь ажлын 14 хоногт багтаан асуудлыг шийдвэрлээгүй эсхүл хариу өгөөгүй тохиолдолд;

4.2. Гэрээний хугацаа дуусаж, цаашид сунгагдахгүй болсон.

4.3. Гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд гэрээг сунгахгүй.

4.4. Давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: үер, гал түймэр, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшиг, халдварт өвчний тархалт, дайн байлдаан, зэвсэгт мөргөлдөөн, террорист үйлдэл, иргэдийн үймээн, нийтийг хамарсан ажил хаялт, эрх бүхий байгууллагаас гаргасан хорио цээр гэх мэт/-ийн нөхцөл байдлын шууд болон шууд бус үйлчлэлийн улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд гэрээг хүчингүйд тооцно.

Тав. Нэмэлт нөхцөл

.....

.....

Зургаа. Гэрээний хариуцлага, дүгнэх

6.1. Талууд гэрээний биелэлтэд тавих хяналтыг хамтран хийж, оны эцэст үр дүнг тооцож гэрээг дүгнэнэ.

6.2. Дүүргийн ойн арга хэмжээ болон дүүргийн хөгжилд оруулах хөрөнгө оруулалтын ажлуудыг талууд харилцан зөвшилцөж, тухай бүрт нь шийдвэрлэн хамтран ажиллана.

6.3. Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага нь Монгол Улсын “Зөрчлийн тухай”, “Хог хаягдлын тухай”, “Байгаль орчныг хамгаалах тухай” болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

6.4. Холбогдох хууль тогтоомж, стандарт, гэрээгээр хүлээсэн үүргээ давтан зөрчсөн, иргэдийн эрх ашгийг ноцтой хохироосон нь тогтоогдсон нөхцөлд аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг холбогдох хуулийн байгууллагатай хамтран бүрэн зогсоох арга хэмжээ авна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

<p>ДУУРГИЙГ ТӨЛӨӨЛЖ:</p> <p>ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛ, НОГООН ХӨГЖЛИЙН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН УДИРДАГЧ БӨГӨӨД ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Ц.ТУНГАЛАГ</p> <p>2021 оны 10 сарын 31 өдөр</p> <p>УТАС: 7023</p> <p>ХУДАЛДАА, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА Ц.ТУНГАЛАГ</p> <p>20... оны сарын өдөр</p> <p>УТАС: 70233617</p>	<p>АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ:</p> <p>“.....” ХХК-ИЙН ЗАХИРАЛ /...../</p> <p>2021 оны 11 сарын 17 өдөр</p> <p>УТАС:</p> <p>“.....” ХХК-ИЙН АЖИЛТАЙ /...../</p> <p>2021 оны 11 сарын 17 өдөр</p> <p>УТАС: 88108444</p>
---	--

Зураг 3. Нийгмийн хариуцлагын гэрээ

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХУДАЛДАА, ҮЙЛДВЭРЛЭЛ,
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

ИЛТГЭХ ХУУДАС

Инновацын төв байгуулсан тухай

2022 оны 2 дугаар сарын 22

Налайх дүүрэг

Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Инноваци, гарааны бизнес, оюуны үйлдвэрлэлийг дэмжих инновацын төв байгуулна” заалтын хүрээнд залуусын бизнес сэтгэлгээг хөгжүүлэх, гарааны бизнес эхлүүлэх шинэ шинэлэг санааг нээж олох, ажиллаж суралцахад таатай орчин нөхцлийг бүрдүүлэх зорилгоор Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн 54м² талбайг бүрэн засварлаж, “Цагаан хулан” ХХК-иар /Сайн тавилга/ компьютерийн ширээ, суудалтай номын сан, кофены хэсэг, хувцасны шкаф, 10 хүний суудалтай ширээ зэрэг иж бүрэн тавилгыг захиалгаар хийлгэн тохижууллаа.

Тус ажлыг нийгмийн хариуцлагын хүрээнд дүүргийн “Тоосго үйлдвэрлэгчдийн Титэм холбоо”-ны гишүүн 10 аж ахуйн нэгжийн дэмжлэг тусламжтайгаар байгуулав.

Засварын өмнөх байдал:



Интерьер дизайны загвар зураг:



Засварын ажил хийгдэж буй байдал:



Инновацийн төвийг тохижуулсан байдал:





Дэмжлэг үзүүлсэн аж ахуйн нэгжийн мэдээлэл:

№	Дэмжлэг үзүүлсэн аж ахуйн нэгжийн нэр	Он сар	Мөнгөн дүн/ төгрөг/
1.	Төгс Эрхэс ХХК	2022 оны 1 сар	2 сая
2.	НК ХХК		2 сая
3.	Хонг Да Интернэшнл ХХК		2 сая
4.	Гэрэлт-Орд ХХК		2 сая
5.	Хоргын чулуу ХХК		2 сая
6.	Кенже ХХК		2 сая
7.	Угалзан цамхаг ххк		2 сая
8.	Баян Эрдэнэ хүрд ХХК		2 сая
9.	Хэлтрэгэ ХХК		1 сая
10.	Цагаан ташаа ХХК		1 сая
Нийт дүн			20 сая

ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛ, НОГООН
ХӨГЖЛИЙН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ
ХӨТӨЛБӨРИЙН УДИРДАГЧ БӨГӨӨД
ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ *Ц.Тунгалаг*
2022 оны 02 сарын 22 өдөр



ХЯНАСАН:
ХУДАЛДАА, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА *Ц.Тунгалаг*
2022 оны 02 сарын 22 өдөр

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:
ХУДАЛДАА, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИТЭН *М.Байгаль* М.БАЙГАЛЬ

Зураг 4. Инновацийн байгуулж, тохижуулав.

Нэгж талбарын дугаар:

1260510266

ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛГЭЙ АЖ
АХУЙ НЭГЖ, БАЙГУУЛЛАГАД ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ, АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ

2022 оны 8 сарын 1 өдөр

№ 01113-2022/01984

Улаанбаатар хот

Монгол Улсын Газрын тухай хууль, Нийслэлийн Засаг даргын 2007 оны 01 сарын 29-ны өдрийн 01113-А/1211/2007 тоот шийдвэрийг үндэслэн газар ашиглуулагчийг төлөөлж, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны мэргэжилтэн Балжинням овогтой Янжинбилэг, газар ашиглагчийг төлөөлж

(Хонг Да интернэшнл ХХК)
(иргэн, аж ахуйн нэгжийн нэр)

Хонг Да интернэшнл ХХК-ны Захирал Li Shihua.

нар энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Нийслэлийн Засаг даргын / Ашигт малтмал газрын тосны газрын даргын 2007 оны 01 сарын 29-ны өдрийн 01113-А/1211/2007 тоот шийдвэр энэхүү газар ашиглуулах гэрээ байгуулах үндэслэл болно.
- 1.2. Гэрээнд дараах зүйлийг заавал тусгана.
- 1.2.1. Газрын байршил, хэмжээ, хил хязгаар, заагийг харуулсан зураг схем.
- 1.2.2. Газар ашиглуулагчаас газар ашиглагчид уг газрыг хүлээлгэн өгсөн акт.
- 1.2.3. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 28-р тогтоолоор баталсан журмын дагуу хийлгүүлж баталгаажуулна.
- 1.2.4. Газрын төлбөрийн тооцоо нийлсэн акт.
- 1.3. Энэхүү гэрээний 1.2.-т заасан бүрдүүлбэр нь гэрээний салшгүй хэсэг бөгөөд түүнийг бүрдүүлж хийгээгүй тохиолдолд уг гэрээг хүчингүйд тооцох үндэслэл болно.

Хоёр. Гэрээний нөхцөл

2.1. Ашиглалтад олгосон газрын нийт хэмжээ	205969 м2
Үүнээс:	
Нэгж талбарын тодорхой хэсгийг ашиглах зориулалт	Тухайн зориулалтаар ашиглах газрын хэмжээ
Уурхайн газар	205969 м2
Уурхайн ашиглалт, олборлолт явуулж буй талбай	28504.33 м2
Уул уурхайн үйлдвэрлэлийн барилга, байгууламжийн талбай	2183 м2
Нөөц газрын талбай	173271.35 м2
Газар ашиглах хугацаа	15

- 2.2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний 2 дугаар хавсралтад заасан тусгай зөвшөөрлийн талбайн солбилцол бүхий кадастрын зураг нь гэрээний хавсралт болно. Тус солбилцлын дагуу тухайн газрын байрлал, хилийн заагийг тогтооно.

2.3. Газрын төлбөрийг нэхэмжлэхийн дагуу Татварын албанд тушаана. Газрын төлбөр төлөгч жилийн төлбөрийг тэнцүү хэмжээгээр хуваан улиралд ногдох төлбөрийг төлөх бөгөөд дараа улирлуудын төлбөрийг урьдчилан төлж болно.

2.4. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр газрын суурь үнэлгээ, газрын үнэлгээний тойрог, зэрэглэл, бүс, газар ашиглах зориулалтын итгэлцүүр, төлбөрийн хувь, хэмжээ болон уулын ажлын төлөвлөгөөнд өөрчлөгдсөн тухай бүр уг өөрчлөлттэй холбогдуулан газрын төлбөрийг 30 хоногийн дотор шинэчлэн ногдуулна.

Гурав. Газар ашиглуулагчийн хүлээх эрх, үүрэг, хариуцлага

3.1. Газар ашиглагч газрыг гэрээний нөхцөл, зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхэд хяналт тавих;

3.2. Газрыг гэрээний нөхцөл, зориулалтын дагуу ашиглаагүй, энэ талаар тавьсан шаардлага болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэгт заасан нөхцөл байдал бий болсон, тусгай зөвшөөрөл цуцлагдсан, дуусгавар болсон тохиолдолд гэрээ цуцалж, Газрын тухай хуулийн 62 дугаар зүйлд зааснаар хохирлыг нөхөн төлөхийг шаардах;

3.3. Газар ашиглах гэрээг жил бүр дүгнэх;

3.4. Холбогдох хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх үүрэг.

Дөрөв. Газар ашиглагчийн хүлээх эрх, үүрэг, хариуцлага

4.1. Газрыг гэрээний нөхцөл, зориулалтын дагуу ашиглах;

4.2. Газар ашиглалтын төлбөрийг хугацаанд нь үйл ажиллагааны үр дүн гарахыг хүлээлгүй төлнө;

4.3. Газрын төлбөрийг хугацаанд нь төлөөгүй бол төлөгдөөгүй төлбөрийн дүнгээс бодож хоног тутам 0,3 хувийн алданги төлнө;

4.4. Өөрийн эдлэн газрын хилийн эргэлтийн цэгүүдийг газар дээр нь тэмдэглэсэн тэмдэгтийг хамгаалалтандаа авч, бүрэн бүтэн байдлыг хариуцах;

4.5. Газар ашиглах гэрээг жил бүр дүгнүүлэх;

4.6. Газар ашиглагч нь уг газрыг ашиглахтай холбоотой авч хэрэгжүүлэх арга хэмжээг хугацаанд нь биелүүлэхийн зэрэгцээ, хот нийтийн аж ахуйг арчлан хамгаалах, засаж тохижуулах үүрэгтэй;

4.7. Газрын тухай хууль тогтоомж, газар ашиглах гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлж ирсэн бол гэрээний хугацаа дуусахад уг газрыг үргэлжлүүлэн ашиглахаар гэрээний хугацааг сунгуулах;

4.8. Газар, байгаль орчныг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах тухай хууль, тогтоомж болон төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэх;

4.9. Газарт учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр тогтоосон журмын дагуу нөхөн төлүүлэх;

4.10. Бусдын газар өмчлөх, эзэмших, ашиглахтай холбогдсон эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй байх;

4.11. Орчны газарт байрлаж байгаа инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээ эрхэлж байгаа мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд саад учруулахгүй байх;

4.12. Гэрээнд зааснаас өөр зориулалтаар газрыг ашигласан бол газар ашиглуулагч гэрээг цуцалж, ашиглалтын явцад учирсан хохирлыг нөхөн төлөх;

4.13. Газар ашиглагч нь албан ёсны хаяг, утасны дугаар өөрчлөгдсөн тохиолдолд ажлын 3 хоногийн дотор газар ашиглуулагч талд мэдэгдэж, гэрээнд тусгуулна.

4.14. Газар ашиглагч нь Газрын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.6-д заасны дагуу уурхайн эдэлбэр газрынхаа 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байлгана;

4.15. Газар ашиглагчийн хүлээх эрх, үүрэг, хариуцлага;

4.16. Холбогдох хууль, тогтоомжоор тогтоосон бусад эрх, үүрэг.

Тав. Газрын талаарх эд хөрөнгийн эрхийн зарим зохицуулалт

5.1. Газар ашиглах эрхийг захиргааны журмаар дуусгавар болгосон тохиолдолд уг газрыг эргүүлэн хүлээлгэн өгөх асуудлыг газар ашиглагч бүрэн хариуцна.

5.2. Газар ашиглагчийн өмчлөлд байгаа газраас салгаж болохгүй барилга байгууламж эд хөрөнгийн өмчлөх эрх өөр этгээдэд шилжвэл газар ашиглах эрхийг дуусгавар болгож шийдвэрлэнэ.

5.3. Газар ашиглах эрх, гэрээний хугацаа дуусгавар болоход тухайн газар дээрх барилга байгууламж бусад эд хөрөнгийг хэрхэх тухай анх эрх олгосон шийдвэрт заасан бол энэ дагуу шийдвэрлэнэ.

Зургаа. Гэрээний нөхцөл

6.1. Энэхүү гэрээг талууд гарын үсэг зуран баталгаажуулснаар тухайн жилдээ хүчинтэй. Талууд жил бүр гэрээний биелэлтийг дүгнэж, харилцан тооцоо хийнэ. Гэрээний биелэлтийг дүгнэхдээ хоёр тал протокол үйлдэнэ.

6.2. Протокол нь энэхүү гэрээний нэгэн адил хуулийн хүчинтэй байх ба гэрээний салшгүй хэсэг байна.

6.3. Гэрээ байгуулагч талууд үндэслэлтэй гэж үзвэл уг гэрээг хэдийд ч дуусгавар болгох эрхтэй боловч нөгөө талдаа 30 хоногийн өмнө мэдэгдэх үүрэгтэй.

6.4. Гэрээний аль ч тал нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд энэ тухай 14 хоногийн өмнө бичгээр тохиролцоно.

Долоо. Бусад

7.1. Газар ашиглагч Монгол Улсын Газрын тухай хууль тогтоомжоор хүлээсэн үүрэг болон газар ашиглуулах энэхүү гэрээний нөхцөл болзлыг биелүүлээгүй, ноцтой зөрчсөн бол гэрээг цуцалж газар ашиглах эрхийг дуусгавар болгоно.

7.2. Энэхүү гэрээтэй холбогдсон маргааныг хэлэлцээрийн журмаар зохицуулна. Хэрэв хэлэлцээрт хүрэхгүй бол Монгол Улсын үндсэн хууль тогтоомжын дагуу шийдвэрлүүлнэ.

7.3. Уг гэрээг Монгол хэл дээр тус бүр 3 хувь үйлдэв. Хувь тус бүр нь нэгэн адил хүчинтэй байна.

Гэрээний талуудын албан ёсны хаяг, харилцах утас:

Газар ашиглуулагч:
Нийслэлийн газар зохион байгуулалтын алба
Нааламчдын зам 1200, Арцатын ам, 4 дүгээр хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17100
Утас: 11315712

Газар ашиглагч: Хонг Да интернэшнл ХХК
Газрын байршил: Налайх дүүрэг, 3 дугаар хороо, Ногоон дов
Газар эзэмшигчийн хаяг: Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 1 дүгээр хороо, 102 тоот
Регистр / улсын бүртгэл /-ийн дугаар: 2861976
Банк, дансны дугаар:
Харилцах утас: 99050809

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Газар эзэмшигчийг төлөөлж: Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны дарга Ганболдсүрэн Цэцэг /...../тамга Ашигласан эзлбэр газар хариуцсан мэргэжилтэн Балжинням овогтой Янжинбилэг гарын үсэг /...../	Газар эзэмшигчийг төлөөлж: Хонг Да интернэшнл ХХК-ны Захирал Li Shihua /...../тамга Гарын үсэг /...../тамга
--	---

Энэхүү гэрээний нэг хувийг 1260510366 дугаар бүхий нэгж талбарын хувийн хэрэгт хадгалав.

Зураг 5. Газар эзэмших, ашиглуулах гэрээ

“Ногоон дов” тоосгоны шаврын ордыг ил аргаар ашиглах төслийн 2022 оны БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Төрийн банк Огноо: 2022/06/21

ТАТВАР ТӨЛСӨН БАРИМТ

Харилцагчийн нэр: Хонг Да интернэшнл
Регистрийн дугаар: 2861976
Төлбөрийн мэдээлэл

Журналын №: 2769996
Теллер №: 9515

№	Тайлант огноо	Татварын төрөл	Нэхэмжлэх, хөрөнгийн дугаар	Төрийн сангийн дансны данс, нэр	Дүн
1	2022 оны 2-р улирал	Газрын төлбөр-Дэд алба	1220601773966	100200400943 НД.Газрын төлбөр	4,338,400.00
Нийт татварын дүн					4,338,400.00
Гүйлгээний шимтгэл					300.00

Данс эзэмшигч 1 нэр: Гарын үсэг..... Төрийн банк/Салбар,
Данс эзэмшигч 2 нэр: Гарын үсэг..... тооцооны төв, касс/.....
..... Гарын үсэг..... Банкны ажилтны нэр, гарын үсэг, тэмдэг/.....
Танд баярлалаа

Нийт төлөх дүн: 4,338,700.00

**ТӨРИЙН БАНК
ТЕЛЛЕР-1110**

<https://192.168.20.86:83/Tax/TaxPrint.aspx?selectValue=payNo&value=2769996> 1/1

Зураг 6. Газрын төлбөр төлсөн баримт

“Ногоон дов” тоосгоны шаврын ордыг ил аргаар ашиглах төслийн 2022 оны БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

ХААН БАНК

ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ / DEPOSIT SLIP

Валют/Currency: MNT

Огноо / Date: 2022/06/21	Сайбар / Branch: 5749	Журнал № / Journal No: 11528062
Дансны дугаар / Account number: 5749061342	Валютын код / Currency code: MNT	
Данс Эзэмшигчийн нэр / Account holder: Чандманьналайх орон нутгийн өмчит ААТГ	Банкны ажилтан № / Bank staff No: 21792	
Гүйлгээний код / Transaction code: 1010 ОРЛОГО БЭЛНЭЭР	Гүйлгээний дүн / Transaction amount: *78,200.00MNT*	
Гүйлгээний утга / Description: 2861976 БОХИР ИНЭ		

ХАРИЛЦАГЧИЙН БӨГЛӨХ ХЭСЭГ / For Customer use only:

Дансны № / Account No:	Дүн тоогоор / Amount: 78,200	Утасны дугаар / Phone No:
Гүйлгээний утга / Description:	Гарын үсэг / Signature: <i>(Signature)</i>	

Дэвсгэрт / Denomination	Дэвсгэрт / Quantity	Дүн / Amount
1		
5		
10		
20		
50	2	*100.00*
100	2	*200.00*
500	1	*500.00*
1,000	1	*1,000.00*
5,000		
10,000		
20,000	4	*80,000.00*
Бүгд/Total		*78,200.00*

Гүйлгээний хураамж / Transaction fee: Банквар / In cash Данснаас / From account

ХААН БАНК
21792-01

Энэ баримад бичигдсэн мэдээллийн үнэн зөвийг хариуцаж, энэ баримтын хариуцагч хүлээхээг гэрэмжлэн үйлдэл болгож мэдэв. By signing in this form, I confirm the accuracy of the information provided here and agree to accept any legal responsibility.

Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 347 тоот тушаалын хавсралт

НЭХЭМЖЛЭХ № . . . 000000001441

Нэхэмжлэгч: _____ Төлөгч: _____
 Байгууллагын нэр: _____ Байгууллагын нэр: _____
 Хаяг: Чандмань Налайх ОНОААТГ Хаяг: ХХК
 Утас: Факс: _____ Гэрээний № _____
 Э шуудан _____
 Банкны нэр: Хаан Банк
 Банкны дансны дугаар: 5749061342 Нэхэмжилсэн огноо: 2022.06.09
 Регистрийн №: _____ Төлбөр хийх хугацаа _____

№	Гүйлгээний утга	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Бохир ус	30	2600	78000
2	Барилга	1	200	200
				7
Дүн				78200
НӨАТ				7820
Нийт дүн				86020

Мөнгөний дүн: Чандмань Налайх ОНОААТГ (үсгээр) Х.Орчи ТӨХ.АТ болно.

САНХҮҮ

Дарга: _____

Зураг 7. Бохир усны төлбөр төлсөн баримт

ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГАА
“ХОНГ ДА ИНТЕРНЭШНЛ” ХХК-ИЙН
УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2022 оны 05 дугаар сарын 25 Дугаар УАД 22/72 Улаанбаатар хот
утас: 7000-3714, 7000-3716

1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр хаяг, утас факс, улсын бүртгэлийн дугаар:
- “Хонг Да Интернэшнл” ХХК, Захирал Ли Ши Хуа, Утас: 8810-8447, Улсын бүртгэлийн дугаар 9019009064, Регистрийн дугаар 2861976.

2. Төслийн нэр, байршил:
- “Хонг Да Интернэшнл” ХХК-ийн тоосгоны үйлдвэр нь Налайх дүүргийн 3 - р хорооны нутаг дэвсгэрт байрладаг.

3. Төсөл хэрэгжүүлэгч:
- “Хонг Да Интернэшнл” ХХК.

4. Тусгай зөвшөөрлийн дугаар болон талбайн координат /X,Y/:
- Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар MV-12112A, талбайн хэмжээ: 20.0 га
Солбицол: 47°44'26.77", 107°17'21.37"

5. Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр төрөл зориулалт:
- “Ногоон дов” тоосгоны шаврын ордыг ил аргаар олборлож, тээвэрлэх, M75-M125 маркын барилгын ханын улаан тоосго үйлдвэрлэх үйл ажиллагаа явуулдаг.

6. Үйлдвэрийн техник, технологи /ажиллах горим, хүчин чадал/:
- Үйлдвэр нь жилд дунджаар 13.88 мян м³ шавар ил аргаар олборлох хүчин чадалтай. Үйлдвэр 66 ажилтантай.

7. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүний хэмжээ:
- 2022 онд үйлдвэр нь 4'000'000.0 ширхэг тоосго үйлдвэрлэнэ /2022 оны үйлдвэрлэлийн бизнес төлөвлөгөө/.

8. Усны эх үүсвэр, нөөц, чанар, хоногт ашиглах хэмжээ /шоо метрээр/:
- Ус хангамжийн эх үүсвэрт ашигладаг худгийн мэдээлэл:

Худгийн дугаар	Солбицол	Гүн, метр	Ундарга, л/сек	Гаргасан он
12750-02803	47°43'59.60" 107°17'35.25"	80.0	5.0	2005

- Үйлдвэрлэх бүтээгдэхүүний хэмжээгээр тооцоход хоногт дунджаар 50.0 м³ газрын доорх ус ашиглана.

9. Усны барилга байгууламжууд /нэр, хүчин чадал, барилга, байгууламжийн хэмжээ хийц/:
- Үйлдвэрийн ус хангамжийн зориулалтаар гаргасан гүний 1 худгаас өөр усны барилга байгууламж ашигладаггүй.

10. Худаг, өргөлтийн станцууд, усны тоолуур /Насосны хүчин чадал, марк/:
- Худагт Стандарт, хэмжил зүйн газраас 2021 оны 05 дугаар сард баталгаажуулсан LXSG загварын 40 мм-ийн голчтой 1702000108 дугаартай тоолуур суурилуулсан. 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн заалт: 01069 м³.
- Тоолуурын хэвийн ажиллагааг хангаж, заалтын тэмдэглэгээг тогтмол хөтөлж, баталгаажуулах шаардлагатай.

11. Дамжуулах байгууламж /Шугам сүлжээний урт, диаметр, эх үүсвэр/:
- Зуурагч төхөөрөмжийн дэргэд 10 м³ эзлэхүүнтэй нөөцийн сантай ба 25 мм диаметртэй ган хоолойгоор зуурах төхөөрөмжтэй холбогддог.

12. Хаягдал бохир усны хэмжээ, цэвэрлэгээний арга, түвшин:

- Үйлдвэрийн шугамын дамжлагаас шингэн хаягдал гарахгүй бөгөөд ахуйн шингэн хаягдлыг доторлогоотой цооногт хуримтлуулж, зориулалтын машинаар зөвөөрлөдөг. Цаашид бохир ус татан зайлуулах гэрээг хийж ажиллах шаардлагатай.

13. Үйлдвэрлэл, үйлчилгээнд усны нөөцийг хэмнэх, эргүүлж ашиглах даалгавар:

- Усыг хэмнэлттэй зарцуулахын тулд ус нөөцлөх санг халиахгүй, тодорхой түвшинд нь худгийг зогсоох төхөөрөмж суурилуулах.

14. Байгаль орчны үнэлгээ, нөхцөл:

- Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланг 2019 онд “Монслоев” ХХК гүйцэтгэж, Байгаль орчин, аялал жуулчлалын яамаар баталгаажуулсан. Цаашид байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгагдсан усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай.

15. Онцгой нөхцөл:

- “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 6561:2015” стандартаас давсан бохирдолтой хаягдал усыг төвлөрсөн сүлжээнд нийлүүлсэн тохиолдолд Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь заалтын дагуу ус ашиглах эрх цуцлагдах нөхцөл үүсэхийг анхаарах.

16. Холбогдох хууль, дүрэм, журам, норм стандартын дагуу усны зарцуулалтыг тооцох:

- 2022 онд үйлдвэр нь 4'000'000.0 ширхэг тоосго үйлвэрлэхээр төлөвлөсөн, Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалаар батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-оор тооцов.

1000 ш ердийн тоосго үйлдвэрлэхэд зарцуулах усны хэмжээ: 0.8 м³ /Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалын 6 дугаар хавсралт/.

2022 онд ашиглах үйлдвэрийн усны хэрэглээг урьдчилан тооцоход:

- Үйлдвэрийн ажилчдын унд ахуйн усны хэрэглээ:

40 хүн х 80 л/хүн х 250 хон = 800.0 м³/жил

- Зам, талбайн усалгаанд:

5'000.0 м² х 2л/м² х 56 хон = 560.0 м³/жил

- Технологийн усны хэрэглээнд:

4'000'000.0 ш тоосго х 0.8 м³/1000ш = 3'200.0 м³/жил

Нийт усны хэрэглээ: 800.0 м³/жил + 560.0 м³/жил + 3'200.0 м³/жил = 4'560 м³/жил

Төлбөр ногдох ус- 4'560 м³/жил - 800.0 м³/жил = 3'760.0 м³/жил.

17. Холбогдох хууль, тогтоол шийдвэрийн дагуу оногдуулах усны нөөцийн төлбөрийн хэмжээ:

- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1-т заасны дагуу унд, ахуйд ашиглах 1'320.0 м³/жил усыг төлбөрөөс чөлөөлнө. Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолоор батлагдсан “Усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ”, Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолоор батлагдсан “Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээ”, Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоолоор батлагдсан “Ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр”-ийг тус тус үндэслэн тооцоход, үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах 1 м³ усны нөөцийн төлбөрт:

9'440 төг/м³ х 20% х 0.1 = 188.8 төгрөг

9'440 төг/м³-Туул голын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ;

20% - Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн зориулалтаар усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ;

0.1 - Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усны шоометр тутамд ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр.

2022 онд ашиглах усны нөөцийн төлбөрийг урьдчилан тооцоход:

ТУУЛ ГОЛЫН
САВ ГАЗРЫН ЗАХИРГАА
833344 373.00т.

$3'760.0 \text{ м}^3/\text{жил} \times 188.8 \text{ төг} = 709'888.0$ /Долоон зуун есөн мянга найман зуун наян найман/ төгрөгийг Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6.5, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т заасны дагуу усны нөөцийн төлбөрийн орлогыг дараа сарын 10-ны өдрийн дотор ус ашиглах дүгнэлтээр тогтоосон хувь хэмжээгээр (188.8 төг) усны тоолуурын заалтаар Налайх дүүргийн Татварын хэлтсийн дансанд төвлөрүүлнэ.

18. Тавих шаардлага, цаашид авах арга хэмжээний талаарх зөвлөмж:

- Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу Нийслэлийн Байгаль орчны газраас ус ашиглах зөвшөөрөл авч, гэрээ байгуулах;

- Ус ашиглуулах дүгнэлтээр ногдуулсан усны нөөц ашигласны төлбөрийн орлогыг хугацаанд нь төлөхгүй үйл ажиллагаа явуулбал Усны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.3 дахь заалтын дагуу ус ашиглах эрх цуцлагдах, Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн дагуу харууллага хүлээх нөхцөл үүсдэгийг анхаарч ажиллах;

- Усны тоолуурын заалтын баталгаа алдагдсан, тоолуурыг шугам хоолойноос салгасан, тоолуургүй үйл ажиллагаа явуулсан тохиолдолд усны нөөц ашигласны төлбөрийг Байгаль орчин, ногоон хөгжил аялал жуулчлалын Сайдын 2015 оны А-301 дүгээр тушаалаар батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-оор тооцож ногдуулахыг анхаарах;

- Гэрээнд зааснаас илүү ашигласан усанд Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор батлагдсан “Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөр тооцох журам”-ын дагуу шатлан өсгөх хэлбэрээр тооцно;


- Хаягдал усны дүгнэлтийг жил бүрийн эхний улиралд багтаан гаргуулах бөгөөд улирал бүр хоёроос доошгүй хаягдал усны сорьц авч итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэн, сүүлийн сарын 15-ны дотор ирүүлж байх;

- Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 17 дугаар зүйлийн 17.1.5-д заасны дагуу сав газрын усны мэдээллийн дэд сан бүрдүүлэхэд шаардлагатай мэдээ тайлан, ус ашиглах зөвшөөрөл, гэрээ, усны нөөц ашигласны төлбөрийн баримт, ус ашиглалтын тайланг 2022 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор Туул голын сав газрын захиргаанд ирүүлнэ;

- Ус ашиглуулах дүгнэлтийг тухайн жилийн эхний хагас жилд багтаан жил бүр гаргуулж байхыг анхаарах.

ХЯНАСАН:


УСНЫ НӨӨЦ, УС АШИГЛАЛТЫГ ЗОХИЦУУЛАХ
АЛБАНЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



П.ЭНХБАЯР

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:

УСНЫ НӨӨЦ, УС АШИГЛАЛТЫГ ЗОХИЦУУЛАХ
АЛБАНЫ МЭРГЭЖИЛТЭН



Д.УРАНЧИМЭГ

Зураг 8. Ус ашиглах дүгнэлт.

ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 4. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт


Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал төг	Нийт зардал Мян.төг	Төлөвлөлтийг хэрэгжүүлсэн байдал
Техникийн нөхөн сэргээлт	Олборлолт хийсэн талбайд техникийн нөхөн сэргээлт хийх	га	0.3	-	Үйл ажиллагааны зардлаас	2022 онд уулын ажлын төлөвлөгөөнд тусгасны дагуу 0.3 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн.



Зураг 9. Нөхөн сэргээлт хийсний дараах байдал

ДӨРӨВ. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2022 онд манай компани дүйцүүлэн хамгааллын чиглэлээр Нийслэлийн байгаль орчны газартай хамтран НБОГ-ын харьяа Хан-Уул дүүргийн 14-р хорооны нутаг дэвсгэрт нэгдсэн зохион байгуулалтаар ногоон зурвас /Мод тарих/ байгуулах ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн.


НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР
Хангарди ордон, Ц.Жигжиджавын гудамж-7/1,
1 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160-0011
Утас: (976-11) 32 77 80, Факс: (976-11) 32 06 69
Цахим хуудас: www.environment.ub.gov.mn

2022.09.10 № 02/401
танай 2022.09.28-ны № 22/01-т

“НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛ
ҮЙЛДВЭРЛЭГЧДИЙН ТИТЭМ ХОЛБОО”
НҮТББ-ИЙН ТЭРГҮҮН Д.ТУНГАЛАГ ТАНАА

Нийслэлийн нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан дүйцүүлэн хамгааллын ажлын хүрээнд Засгийн газрын 2005 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 44 дүгээр тогтоолоор батлагдсан “Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөрийн дагуу Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт нэгдсэн зохион байгуулалтаар ногоон зурвас /Мод тарих/ байгуулах ажлыг хийж гүйцэтгүүлэхээр төлөвлөснийг мэдэгдэж байна. Мод тарих талбайн солбицол:

	Х	Ү
1.	47 46 19.13	106 42 55.58
2.	47 46 16.25	106 43 06.54
3.	47 46 13.73	106 43 04.77
4.	47 46 16.89	106 42 53.95

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

М.НЯМБАЯР

1150500501

9022020311
9077049 5-CST11769

Зураг 10. Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд мод тарих ажлыг хийж гүйцэтгэх хүсэлт

**ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Энэ онд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний ажил төлөвлөгдөхгүй болно.

**ЗУРГАА. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨ**

Ашиглалтын талбайн хэмжээнд түүх, соёлын дурсгалт зүйл илрээгүй.

ДОЛОО. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын гэрээг байгуулж, хуваарийн дагуу тогтмол тээвэрлүүлсэн.

УЛААНБААТАР ХОТ

БАТЛАВ
НАЛАЙХ ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ
ОНӨААТҮГ-ЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОЙ ГҮЙЦЭТГЭГЧ
Д.НАЯНБАЯР

БАТЛАВ
БРИД: 9864976

ХОГ ХАЯГДЛЫГ АЧИЖ ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ

20/06 оны 6 сарын 21 өдөр № Налайх дүүрэг

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

ЗОРИЛТ: Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах, ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг цуглуулах, хадгалах, тээвэрлэх харилцааг зохицуулах, аж ахуйн нэгж байгууллага, ХХ Эрхлэгч нэг бүрийн үүрэг хариуцлагыг тодорхойлж дүгнэх, Монгол Улсын Хог хаягдлын тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, Нийслэлийн ИТХ-ийн Тэргүүлэгчдийн 2009 оны 63-р тогтоолоор батлагдсан “Хот тохижилт, цэвэрлэгээний талаар албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн дагаж мөрдөх журам”, “Журамд өөрчлөлт оруулах тухай” Нийслэлийн ИТХ-ийн 2012 оны 61-р тогтоол, Налайх дүүргийн иргэдийн Төлөөлөнчийн Хурлын 2021 оны 07/02 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхэд оршино.

Энэхүү гэрээг нэг талаас “Тохижилт Үйлчилгээ” ОНӨААТҮГ-ыг төлөөлж, тусгай тусгай ААН-ийг төлөөлж бид харилцан тохиролцож 2022 оны 6 сарын 21-ны өдрөөс хөгжлийн хугацаатай байгуулав.

НЭГ: “ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ” ОНӨААТҮГ-ЫН ЭРХ ҮҮРЭГ


1. Аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн өөрийн тээврийн хэрэгслээр тээвэрлэсэн сар бүр тогтмол өөрийн тээврийн хэрэгслэлээр түрж булах.
2. Хог тээвэрлэлтийн талаарх санал гомдлыг хүлээн авч тухай бүр нь шуурхай шийдвэрлэж байх.
3. Хог хаягдлын төлбөрийн төсөвт төвлөрүүлсэн даруйд хөнгөн шуурхай үйлчилж тогтоосон хугацаанд хогийг тогтмол дарж устгаж байх.

ХОЁР: ГЭРЭЭТ АЖ АХУЙН НЭГЖИЙН ЭРХ ҮҮРЭГ.

1. Хог хаягдлыг агуулах тусгай тагтай савтай байх, хогоо хогийн цэгт заасан байршилд гаргаж асгаж байх, ил задгай асгах шатаах зэргээр орчин бохирдуулахгүй байх.
2. Дүүргийн ЗДТГ-аас хариуцуулсан болон өөрийн орчны газрынхаа хог хаягдлыг байнга цэвэрлэх болон хог хаягдлыг зайлуулах олон нийтийн ажилд оролцож байх.
3. Хог тээвэрлэлтийн талаарх санал гомдлоо холбогдох байгууллагуудад гаргаж шийдвэрлүүлэх.

ГУРАВ: ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

1. Хог тээврийн дундаж км 1 удаагийн ачилтын үнэ 1 х өв өдөр байна. Гэрээний хугацаанд энгийн хог хаягдлыг 30 хоногт удаа байна. Нэмэлтээр ачуулсан тохиолдолд нэмэгдэл төлбөрийг төлнө.
2. Үйлдвэрийн гаралтай (аюултай хог хаягдал, барилга, малын гаралтай) хог хаягдлыг тусгай зориулалтын хог тээврийн авто машинаар нэмэлт төлбөрөөр ачиж тээвэрлэнэ.
3. Хог хаягдлын тухай хуулийн 10.2.3. дахь заалтын дагуу хог хаягдал гаргасан төлбөр төгрөгийг удаа бэлэн бусаар Налайх Тохижилт үйлчилгээ



Зураг 11. Хог хаягдлыг ачиж тээвэрлэх гэрээ

НАЙМ. ОСОЛ, ЭРСДЭЛ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ


Хүснэгт 5. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Тайлбар
Ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт семинарыг тогтмол зохион байгуулж, хамруулах	-
Ажиллагсадыг улиралд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах.	-
Ажиллагсадыг тоосноос хамгаалах хошуувч, хувцас хэрэгслээр хангах	Ажилчдыг тоосноос хамгаалах хошуувч, ажлын хувцас, хөдөлмөр хамгааллын хэрэгслээр бүрэн хангасан.
Нийт зардал	-

ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт 6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Зардал, мян/төг	Тайлбар
Тоосжилт (PM10, PSM, PM2.5) Гадаад болон дотоод орчны дуу чимээ, доргио, чичиргээ Ажлын байрны эрүүл ахуйн үзүүлэлтүүд (тоос, дуу чимээ, гэрэлтүүлэг, чийгшил болон физик бохирдлын түвшин) Бохирдлын цэгэн эх үүсвэр (O ₂ , SO ₂ , NO ₂ , CO)	Уурхайн карьер Ажилчдын тосгон	Жилд 1 удаа 3-р улиралд	100.0	Цаг уур, орчны шинжилгээний газар байгаль орчин хэмжилзүйн төв лабораторитой гэрээ байгуулан шинжилгээ хийлгэсэн. Шинжилгээний дүнгээс харахад ус, агаар, хөрс бүгд стандартын түвшинд байна. Уг ажлын зардалд 144.0 мян.төг зарцуулсан.
Ундны усны бүрэн шинжилгээ	Гүний худаг		50.0	
Хөрсний агро химийн үндсэн үзүүлэлтүүд	Төсөл хэрэгжих талбай Шимт хөрс		40.0	
Төслийг хэрэгжүүлэх эхний жилийн зардлын урьдчилсан дүн			190.0	




МНАС
Accreditation
system
T1.08
MNS ISO/IEC

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohzt@gmail.com

СОРИЛТЫН ДҮН




БАЙГАЛЬ
ОРЧИН ХЭМЖИЛЭГҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИ

Дугаар он/ №	: 2022/ 515
Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас	: “Хонгда” ХХК
Дээжийг авсан хүний нэр, албан тушаал	: Б.Батхшиг, агаарын хэсгийн техникч
Дээжийн тоо, төрөл	: 1, хөрсний сорьц
Хүлээн авсан огноо	: 2022.09.20
Дээжийн тодорхойлолт	: Улаанбаатар хот-Налайх дүүрэг
Шинжилгээний аргын стандарт	: САЗ А01:2022
Шинжилсэн огноо	: 2022.09.22
Хуудасны тоо	: 1/1
Үр дүн:	

№	Сорьц авсан цэгийн нэр	Кадьми (Cd)	Хар тугалга (Pb)	Мөнгөн ус (Hg)	Хром (Cr)	Цайр (Zn)	Зэс (Cu)	Кобальт (Co)	Стронци (Sr)
1	Бааюу орчмоос	<0.005	18.6	0.5	<0.005	84.5	29.9	35.7	384.3
	MNS 5850:2019 / ЗДХ/	3	100	2	150	300	100	50	800

Шинжилгээ гүйцэтгэсэн :
Хөрсний хэсгийн инженер

Хянаж баталгаажуулсан :
Хөрсний хэсгийн инженер




Д.Баярхулан

Б.Даваасүрэн

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн дээжинд хүчинтэй

Зураг 12. Хөрсний шинжилгээний хариу



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohzt@gmail.com



СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№ : 2022/A-275
Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : “Хонгда Интернейшнл” ХХК
Дээжийг авсан хүний нэр, албан тушаал : Б.Батхишиг агаарын хэсэг
Дээжийн тоо, төрөл : 2 агаар, 2 дуу чимээ
Сорьц авсан огноо : 2022.9.20
Дээжийн тодорхойлолт : Налайх дүүрэг 3-р хороо
Шинжилгээний аргын стандарт : MNS 0017-2-5-12:2021, MNS 0017-2-5-11:2021
CA3 A07-2016
Шинжилсэн огноо : 2022.9.27
Хуудасны тоо : 1/1
Үр дүн :

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий мг/м ³	Азотын давхар исэл мг/м ³	Нийт Тоос /TSP/ мг/м ³	Дуу чимээ /ДБА/
1	Бааюу орчим	IX/20	12:00	0.015	0.020	0.140	45
2	Үйлдвэрийн салхин дээр	IX/20	12:35	0.013	0.018	0.087	40
Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 (20 минутын хэмжилт)				0.450	0.200	0.500	60

Шинжилгээ гүйцэтгэсэн:

Байгаль орчны шинжилгээний инженер

Хянаж баталгаажуулсан:

Байгаль орчны шинжилгээний хэлтсийн дарга



Э.Оюунтуяа

Б.Бархасрагчаа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй

Зураг 13. Агаар, дуу чимээний үзүүлэлт



МНАС
Accreditation
system
Т.Л. 08
MNS ISO/IEC

**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohzt@gmail.com

СОРИЛТЫН ДҮН



БАЙГАЛЬ
ОРЧИН ХЭМЖИЛ ЗҮЙН ЛАБОРАТОРИ

Дугаар он/№	: 2022/ Ц-164
Сорьцыг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас	: “Хонгда Интернейшнл” ХХК
Сорьцыг авсан хүний нэр, албан тушаал	: Б.Батхишиг, БОХЗТЛ
Сорьцын тоо, төрөл	: 1, ус
Сорьцыг авсан огноо	: 2022.09.20
Сорьцын тодорхойлолт	: Усны сорьц
Шинжилгээний аргын стандарт	MNS ISO 6836:2020, MNS 6833:2020 MNS ISO 7150-1:2006, MNS 6779:2019 MNS 6834:2020, MNS ISO 6878:2001 MNS 4430:2005, MNS 6272: 2011
Шинжилсэн огноо	: 2022.09.120-2022.10.03
Хуудасны тоо	: 1 /2
Үр дүн	: 1

Сорьцын нэр	Ж/б	ПИЧ	NH ₄	NO ₂	NO ₃	PO ₄	Fe	F
	мг/л	мг/л	мгN/л	мгN/л	мгN/л	мгP/л	мг/л	мг/л
Найлах дүүрэг 3-р хороо Худгийн ус	2.8	4.3	0.06	0.013	1.02	0.005	0.19	илр
MNS 0900:2018	-	-	1.5	1.0	50	3.5	0.3	0.7-1.5

Тайлбар: Ж/б- Жинлэгдэгч бодис, ПИЧ-Перманганатын Исэлдэх Чанар, ИЛР-Илрээгүй

Шинжилгээ гүйцэтгэсэн инженер: 


Хянаж баталгаажуулсан инженер: 

Б.Жавзандулам

Ц.Мийдүв

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

Зураг 14. Усны шинжилгээний хариу



Зураг 15. Агаар, ус, хөрсний шинжилгээ авч буй байдал

АРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсруулан холбогдох байгууллагуудад танилцуулахаар хүргүүлсэн болно.

ДҮГНЭЛТ

Манай компани нь 2022 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- ✓ Тоосжилт ихтэй үед зам усалгааг тогтмол хийж байсан.
- ✓ Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд НБОГ-тай хамтран ажилласан. Уг ажлын зардалд 2 сая төгрөг зарцуулсан болно.
- ✓ Хог хаягдлын гэрээ байгуулж, гэрээний дагуу тээвэрлүүлж байсан.
- ✓ Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангаж ажилласан.
- ✓ Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд агаар, хөрс, усны шинжилгээ авч лабораторид шинжлүүлсэн.